

## ХҮН АМ БА ХӨГЖЛИЙН АСУУДЛААРХ УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ

Улаанбаатар хот

2013 оны 9-р сарын 30

2013 оны 9 дүгээр сарын 30-ны энэ өдөр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо Хүн ам ба хөгжлийн асуудлаархи Үндэсний дээд хэмжээний уулзалтад оролцсон Улсын Их Хурлын гишүүд, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчид бид 2014 оноос хойшхи бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг хэлэлцээд:

1994 онд Египетийн Кайр хотноо болсон Хүн ам ба хөгжлийн асуудлаарх Олон улсын бага хурлаас баталсан Үйл ажиллагааны хөтөлбөр /хавсралтын хамт/, түүний цаашдын хэрэгжилтийг хангах гол арга хэмжээг тодорхойлсон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1999 оны баримт бичиг, хэрэгжилтийн үнэлгээнд тулгуурлан гаргасан зөвлөмжүүд,

2013 оны 9 дүгээр сарын 16-20-нд Тайландын нийслэл Бангкок хотноо болсон Хүн амын асуудлаарх Ази номхон далайн 6 дугаар бага хурлаас баталсан “Хүн ам ба хөгжлийн асуудлаарх Ази номхон далайн тунхаглал”-ыг иш үндэс болгож,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн жаран тав дугаар дугаар хуралдааны үеэр зохиогдсон Мянганы хөгжлийн зорилтуудын талаарх Өндөр хэмжээний уулзалтаас баталсан баримт бичиг,

Тогтвортой хөгжлийн асуудлаарх НҮБ-ын бага хурлын үеэр олон орны төрийн тэргүүнүүд, өндөр хэмжээний төлөөлөгчид зөвшилцөж, Рио де Жанейрогийн зарчмуудыг мөрдөхөө дахин амлаж, ялангуяа нийтлэг бөгөөд төрөлжсөн үүрэг хариуцлага хүлээх, бүх нийт, ялангуяа хүүхэд, өсвөр үе, залуучууд, эмэгтэйчүүд, өндөр настнууд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх тухай асуудлуудыг тусган

баталсан “Бидний хүсч буй ирээдүй” баримт бичигийг хүндэтгэн хүлээн зөвшөөрч,

Хүн ам ба хөгжлийн асуудлаарх Олон улсын бага хурлын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг ахиулж, зорилго зорилтуудад хүрэхийн төлөөх ажлаа үргэлжлүүлэх амлалтыг дахин авч дараах тунхаглалыг гаргаж байна:

Бид Монгол Улсын төрд хүн ам ба хөгжлийн асуудлуудыг шийдэхэд чиглэсэн урт хугацааны стратеги боловсруулж, үндэсний түвшинд улс төр, нийгэм эдийн засгийн тогтолцоонд тусгахыг зөвлөмж болгож байна. Хүн ам ба хөгжлийн асуудлыг уялдуулах, бүх нийтэд, ялангуяа өсвөр үе, залуучуудад чиглэсэн нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, жөндөрээс үүдэлтэй ялгаварлан гадуурхалт, жөндөрт суурилсан хүчирхийллийг устгахын төлөөх хүчин чармайлтыг нэмэгдүүлж, хөхүүлэн дэмжих нь зүйтэй гэж үзэж байна.

Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар төрөөс баримтлах цогц бодлогыг (2014-2024) боловсруулж хэрэгжүүлснээр хүн амын динамик хөдөлгөөнийг нийгэм эдийн засгийн хөгжилтэй нягт уялдуулах, гэр бүлийн хөгжлийг дэмжихийн зэрэгцээ хүний, ялангуяа залуучуудын хөгжлийн асуудалд түлхүү анхаарахыг дэмжиж байна. Одоо боловсруулж буй Хүн амын хөгжлийн үндэсний цогц бодлогод бүх насны бүлгийн хүн амын амьдралын чанарыг сайжруулах зорилгыг дэвшүүлж, Монгол Улсын хүн амын эрт эдүгээ болон ирээдүйн нөхцөл байдалд сайтар дүн шинжилгээ хийсний үндсэн дээр, ялангуяа хүн ам зүйн цонх үеийн урамшууллын үед залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжихийн ач холбогдол болон ахмад насны хүн амын

тоо хурдацтайгаар өсөх хандлагыг тусган боловсруулан хэрэгжүүлэх явдлыг сайшааж байна.

Бид эрүүл мэнд нь тогтвортой хөгжлийн нэгэн голлох үзүүлэлт мөн гэдгийг хүлээн зөвшөөрч, хүн амын эрүүл мэндийн төлөөх нийгмийн болон байгаль орчны нөхцлүүдийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг бүх нийтийн оролцоотойгоор шударга, эдийн засгийн хувьд үр дүнтэйгээр хангах үүрэгтэйгээ ухамсарлаж байна.<sup>21</sup>

Бид бэлгийн амьдралын цогц боловсрол ба бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ, тухайлбал эх нярайн эрүүл мэндийн үйлчилгээ, өсвөр үе залуучуудад ээлтэй үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, эдгээрт төсвөөс хуваарилж байгаа хөрөнгийг нэмэгдүүлж, зарцуулалтыг хянаж ажиллахаа баталж байна.

Бид бүх нийтийн нөхөн үржихүйн эрхийг хамгаалж, хот хөдөө дэх нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх үүрэг амлалт авч байна. Энэ хүрээнд эмэгтэйчүүд, өсвөр үе залуучууд, орлого багатай иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөдөлгөөнт хүн ам, шилжин суурьшигчдын эрхийг хамгаалахад тусгайлан анхаарч, ахмад настнуудын хэрэгцээг онцгойлон авч үзнэ гэдгээ баталж байна. Энэхүү зорилтонд хүрэхийн тулд эрэгтэйчүүдийн оролцоо чухал гэдгийг ойлгож байна.

Монгол орныг хөгжүүлэх үйлсэд бүх түвшинд хамтран ажиллаж буй бүхий л талуудыг бэлгийн замаар дамжих халдвар, түүний дотор хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалт нэмэгдэхээс урьдчилан сэргийлэхийн төлөө нэн даруй нэгдэж, нягт хамтран ажиллаж, ялангуяа өсвөр үе залуучуудад онцгой анхаарал хандуулахыг уриалж байна.

Нас, хүйс, гэрлэлтийн байдал, жендэрийн чиг хандлага болон бусад шинж чанараасаа үл хамааран хүн

бүрт гэр бүл төлөвлөлтийн аюулгүй, үр дүнтэй, тохиромжтой, боломжийн үнэтэй, орчин үеийн арга хэрэгслийн талаар бүрэн дүүрэн мэдээлэл авч, сайн дурын үндсэн дээр сонгон хэрэглэх боломжийг бүрдүүлсэн хүний эрхэд суурилсан гэр бүл төлөвлөлтийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээ амлаж байна.

Бид боловсролын тогтолцооны бүхий л түвшинд амьдралын ур чадварт суурилсан бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролын чанарыг сайжруулж, ач холбогдлыг дээшлүүлэх замаар эрүүл зан үйл, эрсдэлгүй бэлгийн зан үйлийг дэмжиж, гэр бүл төлөвлөлтийн хангагдаагүй хэрэгцээг болон бэлгийн замаар дамжих халдварыг бууруулах үүрэг амлалт авч байна.

Бид Жендэрийн тэгш байдлын тухай хуулийг цаг алдалгүй хэрэгжүүлж, түүнийг үндэсний хөгжлийн бодлого, стратегид нэн даруй тусгахыг онцолж байна. Энэ хүрээнд бодлого боловсруулах, хууль тогтоох бүхий л түвшинд эмэгтэйчүүдийн бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоог хангаж, эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхижилтад анхаарч, эдийн засгийн нөөцийг эмэгтэйчүүдэд бүрэн дүүрэн, тэгш хүртээмжтэй байлгах, ялангуяа газар, эд хөрөнгө болон бусад зүйлсийг өмчлөх эрхийг хангахын чухлыг онцлон тэмдэглэж байна.

Бид охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүхий л хэлбэр хэт тархмал байгаад сэтгэл зовниж, эдгээрийг арилгах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хүчин чармайлтыг эрчимжүүлэх, жендэрт суурилсан хүчирхийллийн хариу арга хэмжээг бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн бүх үйлчилгээ, хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх үүрэг амлалт авч байна.

Бид тэнцвэргүй, тэгш бус байдалд нөлөөлөх нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийг анхаарч, эдгээрийг бодлого, хууль тогтоомж, хөтөлбөрүүдийн хүрээнд шийдэж, нийгмийн хамгааллын доод хэмжээг хангах НҮБ-ын зөвлөмжийг дагах замаар эмзэг бүлгүүдийн эмзэг байдлыг бууруулахын төлөө хичээн зүтгэнэ.

21 [http://mne.mn/v3/wp-content/uploads/2013/03/Rio-Outcome\\_mon\\_PDF.pdf](http://mne.mn/v3/wp-content/uploads/2013/03/Rio-Outcome_mon_PDF.pdf)

Иргэний нийгмийн байгууллагууд нь хариуцлагын тогтолцоонд хяналт тавьж, иргэд ба шийдвэр гаргагчдыг холбох гүүр болдогийн хувьд Хүн ам ба хөгжлийн асуудлаарх Олон улсын бага хурлын зорилтуудыг эрчимтэйгээр хэрэгжүүлж, 2015 оноос хойш хөгжлийн зорилтуудыг тодорхойлоход чухал үүрэгтэйг тодотгож байна.

Хүн амын динамик хөдөлгөөнийг хөгжлийн асуудал, зорилтуудтай илүү сайн уялдуулахын тулд үндэсний байгууллагуудын хүн ам ба хөгжлийн асуудлаархи чадавхийг бэхжүүлэхийн ач холбогдлыг ойлгож байна.

Бид хөгжилд хүрэхэд үр дүнтэй, тэнцвэртэй, бодлого хөтөлбөрт суурилсан санхүүжилт шаардлагатайг ухамсарлаж дээр дурьдсан хөгжлийн зорилтуудыг эн тэргүүнд тавьж хэрэгжүүлэх хүчин чармайлт гаргахаа амлаж байна.

Энэхүү ТУНХАГЛАЛЫГ хэрэгжүүлэхэд хүн ам ба хөгжлийн асуудлаарх салбар дундын уялдаа холбоог сайжруулахад анхаарна.

Засгийн Газар, олон улсын түншлэгч байгууллагууд болон иргэний нийгмийн байгууллагууд хүн ам ба хөгжлийн асуудалд хөрөнгө босгон хамтарч ажиллахаа илэрхийлж байна.

Эцэст нь, Улсын Их хурлын гишүүд, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчид бид төлөөлж буй иргэдийнхээ, ялангуяа өсвөр үе залуучууд, эмзэг бүлгийнхний тэгш оролцоог бүхий л бодлого, хууль тогтоомж, хөтөлбөрүүдэд хангаж, хүний эрхийг хэрэгжүүлж, хүсэл тэмүүллийг нь тусгана гэдгээ амлаж байна.

*Дээд хэмжээний уулзалтад оролцогчид*

## ULAANBAATAR DECLARATION ON POPULATION AND DEVELOPMENT

30<sup>th</sup> September, 2013

Ulaanbaatar

We, Parliamentarians and Government Representatives, meeting in Ulaanbaatar, Mongolia, on 30<sup>th</sup> of September, 2013, at the National High Level Meeting on Population and Development: Commitment Beyond 2014, issue the following declaration:

*Recalling* the Programme of Action adopted by the International Conference on Population and Development (ICPD) in Cairo in 1994, and its annexes, and the Key Actions for the Further Implementation of the Programme of Action of the ICPD adopted in 1999 and the recommendations arising from their subsequent reviews,

*Also recalling* the outcome document of the Sixth Asian and Pacific Population Conference, held in Bangkok from 16 to 20 September 2013,

*Further recalling* the outcome document of the High-level Meeting of the United Nations General Assembly on the Millennium Development Goals at its sixty-fifth session,

*Welcoming* the outcome document of the United Nations Conference on Sustainable Development, entitled "The Future We Want", in which the Heads of State, Government and high-level representatives reaffirmed the Rio principles, including common, but differentiated responsibilities, and a commitment to promoting a safe and healthy living environment for all, particularly children, youth, women, older persons and people with disabilities,

We reaffirm our commitment to continue work for achieving the aims and goals of the ICPD Programme of Action.

We urge our Government to develop long-term strategies to address population and development issues and integrate them into socio-economic and political systems.

We must make, and encourage, greater effort to link population and development, and to increase access and improve the quality of reproductive health services for all people, particularly adolescents, in addition to enhancing and promoting efforts to abolish gender-based discrimination and violence.

We acknowledge that development and implementation of the national comprehensive policy on population development (2014-2024) will integrate population dynamics into the socio-economic development of Mongolia, promoting the equitable development of families with a strong focus on supporting young people's development. We commend the national comprehensive policy on population development, which aims to improve the quality of life for all age groups. We laud the policy for addressing the importance of supporting young people's employment during the current demographic window of opportunity, while also addressing the growing elderly population.

We recognize that health is one of the crucial issues for sustainable development and commit to working with all partners to improve justice, economic efficiency and environmental protection, as key foundations for improving public health<sup>22</sup>.

We commit to improving the quality of comprehensive sexual education, in addition to enhancing access to and quality of sexual and reproductive health services, particularly maternal, child and youth-friendly health services, with clearly identifiable targets and budget allocations.

We commit to protecting and strengthening the reproductive rights of all people, while also increasing the accessibility of reproductive health and family planning services in urban and rural areas. Priority attention will be paid

<sup>22</sup> [http://mne.mn/v3/wp-content/uploads/2013/03/Rio-Outcome\\_mon\\_PDF.pdf](http://mne.mn/v3/wp-content/uploads/2013/03/Rio-Outcome_mon_PDF.pdf)

to enhancing the rights of women, children, youth, people living in poverty, people with disabilities, mobile populations and ethnic minorities and elderly people. We recognize that male involvement is essential in recognizing this objective.

We will encourage all partners in development, at all levels, to act immediately, in a coordinated and concerted effort, to prevent the further spread of STIs/HIV, while giving special attention to adolescents and young people.

We commit to increase access to human rights-based family planning services by ensuring access to contraceptive services with comprehensive information about, and voluntary access to and choice of, the widest possible range of safe, effective, affordable and modern methods of contraception, so that individuals are able to voluntarily exercise free, responsible and informed reproductive choice, regardless of sex, age, marital status and other characteristics.

We commit to improve the relevance and quality of life skills-based sexual and reproductive health education at all levels of the education system to promote healthy sexual behavior and reduce unmet needs for family planning and STIs.

We support implementation of the Gender equality Law and its incorporation into national development policies in a timely manner. Throughout this process, we will ensure women's comprehensive and effective participation at all levels of policy development and law implementation. We will pay particular attention to women's sustainable economic empowerment and ensuring their rights to property.

We are concerned about the pervasiveness of violence against women and girls in all its different manifestations, and commit to intensify efforts to prevent and eliminate all forms of violence against women and girls, and integrate responses to gender-based violence in all sexual and reproductive health services and programmes.

We commit to focusing on social, economic and structural determinants of inequality and inequity and ensure these determinants are addressed in laws, policies and programmes. We will strive to decrease the vulnerabilities of marginalized and vulnerable groups in accordance with the United Nation's recommendations on social protection floor.

We recognize that civil society organizations have an important responsibility for accelerated achievement of ICPD goals and promoting an inclusive post-2015 development agenda, as key groups for accountability monitoring and by being a bridge between people and decision makers.

We recognize the importance of enhancing the capacity of national institutions related to population and development to better incorporate population dynamics into broader development objectives.

We recognize the need for effective and equitable policy and program-based financing for development, and an unwavering commitment to prioritizing the development priorities of this declaration.

We commit to improving inter-sectoral cooperation to address population and development issues reflected in the DECLARATION.

We recognize that Government, international organizations and civil society organizations must cooperate for resource mobilization and effective action to successfully address population and development issues.

Finally, we, Members of Parliament and Government, resolve to ensure the participation, inclusion, human rights and aspirations of the people we represent – especially young people and the most marginalized, is reflected in all of our laws, policies and programmes.

*High Level Meeting Participants*